



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/62

Мөрөн сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны ажлын төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Энэхүү захирамжаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, хагас жилийн тайланг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор, бүтэн жилийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д даалгасугай.

ДАРГА




Ш.ИДЭРБАЯСГАЛАН

ХӨВСГӨЛ АЙМГИЙН 2023 ОНЫ АВЛИГЫН
ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


Аймгийн Засаг даргын 2023 оны 02-
дугаар сарын 08-ны өдрийн А/Б.Д.
дугаар захирамжийн хавсаргалт




№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Харуулах эзэн
1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1.1 Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хургуулах.</p> <p>1.2 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг "Түмний ТВ", "Эрх чөлөө сонин", "Хөвсгөл ТВ" зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн сүлжээгээр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, зурагт хуудас зэргийг иргэдэд хүргэсэн байх.</p> <p>1.3 Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.</p> <p>1.4 Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах.</p> <p>1.5 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшил 110" мэдээллийн самбар ажиглуулах.</p>	<p>-Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийг дуусгаж тайланг хүргүүлсэн байх.</p> <p>-Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх.</p> <p>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (Түгээсэн тоо, давтамж, авсан хандлагтын тоо)</p> <p>-Дэмжиж хамтран ажилласан байх.</p> <p>-Салбар нэгж, орон нутагт зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх.</p> <p>-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа гэх мэт соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх.</p> <p>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Сумд, байгууллагын удирдлагууд</p> <p>Сумд, байгууллагын удирдлагууд</p> <p>Сумд, байгууллагын удирдлагууд</p>

	<p>1.6 Авлигатай тэмцэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын явц биелэлт, үр дүнг байгууллагын цахим хуудаст тухай бүр нийтэлж иргэд олон нийтийг мэдээллээр хангах.</p> <p>1.7 "Хөвсгөлийн өнгө" сайттай хамтран авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах "Мэдээллийн цаг"-ийн тусгай хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулах.</p> <p>1.8 Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглүүлж, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонинны нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>хүсэлтээ илэрхийлэх боломжийг бүрдүүлэх; -Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх.</p> <p>-Иргэдэд мэдээллүүдээ ил тод хүргэсэн байх.</p> <p>-Иргэд, олон нийтэд хүрэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааны чанар хүртээмж дээшлэх.</p> <p>-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм уоуtбе суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>Сүмд, Байгууллагын удирдлагууд</p>  <p>Аймгийн Засаг даргын Тамгын газар</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, АИТХ</p>
2	<p>Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, төрийн байгууллагын албан</p>	<p>2.1 Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлэх.</p> <p>-Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх.</p>	<p>Сүмд, Байгууллагын удирдлагууд</p>

<p>хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах</p>	<p>2.2 Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах.</p>	<p>-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо.</p>	<p>Сумд, байгууллагын удирдлагууд</p>
<p>3</p>	<p>2.3 Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд, залуучуудад хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнах.</p>	<p>-Сурталт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх. -Хамрагдсан хүүхэд, залуучууд, иргэдийн тоо.</p>	<p>Сумд, байгууллагын удирдлагууд</p>
<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийн дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь хүргүүлэх</p>	<p>2.4 Сургагч багш бэлтгэх сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулж, хамтарсан соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах.</p>	<p>-Сургагч багш бэлтгэгдсэн байна; -Хамтарч сурталчилгаа зохион байгуулсан байна.</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</p>
<p>3</p>	<p>2.5 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд хамтран ажиллах.</p>	<p>-Авлига, албан тушаалын гэмт хэргийн гаралт буурсан байна; -Сургалт сурталчилгаа зохион байгуулсан байх.</p>	<p>АИТХ, ГХУСАЗСЗ</p>
<p>3</p>	<p>3.1 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу, тайланг хүргүүлсэн байх.</p>	<p>Сумд, байгууллагын удирдлагууд</p>
<p>3</p>	<p>3.2 Мөрдөгчийн мэдэгдлийг хэрэгжүүлэх.</p>	<p>-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу, тайланг хүргүүлсэн байх.</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газар</p>
<p>3</p>	<p>3.3 Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан ажлыг тайлагнах.</p>	<p>-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу, тайланг хүргүүлсэн байх.</p>	<p>Сумд, байгууллагын удирдлагууд</p>
<p>3</p>	<p>4.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллагаас гаргасан санал санаачилга уриа, аянд нэгдэж хамтран зохион байгуулах.</p>	<p>-Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санал санаачилга өрнүүлсэн байх.</p>	<p>Сумд, байгууллагын удирдлагууд</p>

4	Байгууллагын авлигатай удирдлагын тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.2 Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах. 4.3 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөгд өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	-Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санал санаачилга өрнүүлсэн байх. -Санал тусгасан байх.	Сүмд, байгууллагын удирдлагууд 
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.	5.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйччилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	-Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх.	Сүмд, байгууллагын удирдлагууд
6	Байгууллагын ажиглаганы нээлттэй нээлттэй сайжруулах	5.2 Авлига, албан тушаалын гэмт хэрэгт иргэний хяналтыг сайжруулж, төрийн бус байгууллагын оролцоог дэмжин мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлнэ. 6.1 Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах. 6.2 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах.	-Авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэний хяналт сайжирсан байх. -Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх.	Аймгийн Засаг даргын Тамгын газар Сүмд, байгууллагын удирдлагууд
7	Авлигын эрсдэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	7.1 Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх.	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Сүмд, байгууллагын удирдлагууд

	<p>7.2 Судалгаа хийж аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас үйлчилгээ авахад тулгардаг бэрхшээлийг тогтоох, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, судалгааны үр дүн, санал дүгнэлтийг хэлэлцүүлэх.</p>	<p>-Судалгааны үр дүн, санал дүгнэлтийг хэлэлцүүлсэн байна.</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газар</p> 
--	---	---	--

_____ 00000 _____